

21 АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН



Улаанбаатар хот
2017 он

**“ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭМНЭЛГИЙН ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ
ТАНИЛЦАХ” АЖЛЫН ХЭСГИЙН НЭГДСЭН ТАЙЛАН**

Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/143 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг ЭМЯ-ны дарга, ахлах мэргэжилтнээр ахлуулсан ЭМХТ-ийн МТЭТТАлбаны эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга хариуцсан мэргэжилтнүүд, ЭМЯ-ны харьяа Төв эмнэлгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдээс бүрдсэн 5 баг 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдөр хүртэл 21 аймагт 5 чиглэлд зэрэг ажиллаа.

Зорилго:

- Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн үйл ажиллагаатай танилцах, засвар үйлчилгээний тулгамдсан асуудлыг шийдвэрлэх

1-р баг /**Хэнтий**, Дорнод, **Сүхбаатар**, Говьсүмбэр /
Ахлагч Н.Гэрэлт-Од, гишүүд Б.Батцэнгэл, Г.Буянхүү,
Т.Байгаль

2-р баг /Дархан-Уул, **Сэлэнгэ**, Орхон, Булган, **Хөвсгөл**/
Ахлагч Л.Мөнхтулга, гишүүд Б.Сансармаа,
А.Баянмөнх, С.Алтанбагана

3-р баг /**Увс**, **Баян-Өлгий**, Ховд/
Ахлагч Б.Энхжаргал, гишүүд Б.Санж-Очир,
Н.Наранбаатар, Н.Тунгалаг

4-р баг /Төв, Дундговь, Өмнөговь, **Дорноговь**/
Ахлагч Ц.Хандармаа, гишүүд Ц.Уянга, О.Баярцэцэг, Ж.Ганбат

5-р баг /Өвөрхангай, **Баянхонгор**, **Завхан**,
Архангай, **Говь-Алтай**/

Ахлагч Д.Очирбат, гишүүд С.Солонго, Б.Батцоож,
Ц.Ганбат, Г.Оюунцэцэг



Ажлын хэсэг 8 зорилтын хүрээнд ажилласан. Зорилт тус бүрээр хийсэн ажлын тайлан нэгтгэн гаргалаа.

Зорилт 1. Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй газар дээр нь танилцах

Багууд тухайн аймгийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн удирдлага, инженер техникийн ажилтантай уулзаж ярилцан, эмнэлгийн барилга байгууламж, цахилгаан систем, эмнэлгийн хийн систем, агааржуулалт, газардуулгын системтэй танилцаж тулгамдаж буй асуудлыг судаллаа.



Зураг 1. Н.Гэрэлт-Од ахлагчтай I баг
Дорнод аймгийн БОЭТ



Зураг 2. Л.Мөнхтулга ахлагчтай II баг
Орхон аймгийн БОЭТ



Зураг 3. Б.Энхжаргал ахлагчтай III баг
Увс аймгийн нэгдсэн эмнэлэг



Зураг 4. Ц.Хандармаа ахлагчтай IV баг
Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлэг



Зураг 5. С.Солонго ахлагчтай V баг
Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газар

Хүснэгт 1. Барилга байгууламжтай холбоотой санал, хүсэлт

№	Аймаг	Барилга байгууламж нөхцөл байдал, тулгамдсан асуудал	Цахилгааны нэмэлт үүсвэр	Нэгдсэн систем		
				Газардуулга	Агааржуулалт	Эмнэлгийн хий
1	Архангай НЭ	1990 онд ашиглалтанд орсон 2010 он дээврийн засвар хийгдсэн их засварт ороогүй 25 жил болж байна. Тус НҮЭМК-нь эх нярайн чиглэлээр 2-р шатлалын тусламж үйлчилгээг үзүүлдэг. Жилдээ 1600-1700 орчим эх төрдөг одоогоор тус барилгын цахилгаан сантехник, элэгдэлд орсон, хуучирч муудсан, дээрвээс ус нэвтэрч зарим хэсгээр мөөгөнцөр үүссэн. Нийт цонхны 70 орчим хувь хуучин модон цонхтой тус цонх гажиж зай завсар гарсан дулаан алдалт их өрөө тасалгаанууд сэрүүн зэрэг нөхцөл байдлаас үүсэн иргэдэд тусламж үйлчилгээ үзүүлэхэд хүндэрэл үүсч байна. Иймээс барилгын их засвар хийлгэх нь нэн тэргүүнд шийдвэрлүүлэх тулгамдсан асуудлын нэг болоод байна. 2013.2014 оны хөрөнгө оруулалтад тусгасан хэдий ч санхүүжилт байхгүй улмаас шийдвэрлэгдээгүй. их засварын зураг төсөл хийгдэн ЭМЯ-нд хүргэгдсэн	Хонда мотортой	Yes	No	Эрчимт эмчилгээний тасагт хучилтөрөгчийн шугамтай
2	Баянхонгор НЭ	АНЭ нь 11 хэсэг барилгатай, халдвартын эмнэлэг 2012 онд, 50 ортой төрөх, эмэгтэйчүүдийн тасаг 2014 онд, хүүхдийн 100 ортой эмнэлэг 1978 онд, амбулаторийн хэсэг 1984 онд, мэс засал, яаралтай тусламжийн хэсэг 1980 онд, ариутгал, угаалгын хэсгийн барилга 1957 онд тус тус баригдсан. Хуучин барилгад их засвар хийгдэж байгаагүй, зарим хэсэг, нэгжийн хана мөөгөнцөртсөн, орчны эрүүл ахуйн шаардлага хангахгүй, нэгдсэн агааржуулалтын системгүй.		No	No	No
3	Булган НЭ	Нэгдсэн эмнэлгийн барилга 1989 онд баригдсан, дээврийн болон сантехникийн жижиг засварууд хийгдсэн. Халдварт сүрьеэгийн барилгын хугацаа дууссан, аргагүйн эрхэнд бүслүүр төмрөөр бэхлэгээ хийсэн. Төрөх эмнэлгийн барилгын 3-р давхар халаалт байдаггүй тул өвлийн улиралд үйл ажиллагаа явуулах боломжгүй Хавдрын тасгийн халаалт муу	Цахим эрүүл мэнд төслөөр нийлүүлэгдсэн генератор холболт хийгдээгүй.	No	No	No
4	Баян-Өлгий НЭ	1970 онд ашиглалтад орсон. Цахилгааны болон сантехникийн монтаж хуучирч муудсан.		No		
5	Говь-Алтай НЭ	Нэгдсэн эмнэлгийн барилга 1983 онд баригдсан, 2010 онд их засвар хийгдсэн. Нэгдсэн агааржуулалтын системгүй.		No	No	No
6	Говьсүмбэр НЭ	1. Барилгууд тус тусдаа олон хэсгээс бүрддэг тул халаат, харуул хамгаалалт гээд хүндрэлтэй байдаг. 2. Шинэ барилгын зураг төсөв Нэгдсэн эмнэлгийн барилгын зураг төсөв 2014 онд хийгдсэн 7,1 тэрбум төгрөг шаардлагатай 3. Хүүхдийн эмнэлгийн барилга МХЕГ азраас ашиглах боломжгүй гэсэн дүгнэлт гарсан, өрөө тасалгаа хүрэлцдэггүй.	Цахим эрүүл мэнд төслөөр нийлүүлэгдсэн генератор холболт хийгдээгүй.	Зарим тоног төхөөрөмжийг газардуулгад холбосон	Yes	Төрөх тасаг, мэс заслын тасагт хучилтөрөгчийн шугамтай.
7	Дархан-Уул	НЭ-ийн вакум хагалгааны өрөө 2013 онд ашиглалтад орсон боловч одоогоор ажилладаггүй.	Цахим эрүүл мэнд төслөөр нийлүүлэгдсэн генератор холболт хийгдээгүй. Барилга байхгүй. Цахилгаан нөөц 2 мотортой.	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХХК-д газардуулгаа шалгуулахаар хүсэлт өгсөн.	No	Хүүхдийн эмнэлэг, сэхээний тасаг, төрөх эмнэлгийн хагалгааны өрөөнд хучилтөрөгчийн системтэй
8	Дорнод БОЭТ	-	Yes	No	No	No
9	Дорноговь НЭ	50 ортой төрөх эмнэлгийн барилга царцсан.				
10	Дундговь НЭ		Yes	7 барилгаас 2 барилга газардуулгын системд холбогдсон	Yes	No
11	Завхан НЭ			Барилгын зарим хэсгүүд газардуулгын системд холбогдсон	Yes	No
12	Орхон БОЭТ	БОЭТ-ийн барилга 1983 онд баригдсан, Сантехник болон цахилгааны монтаж муутай. Засвар хийгдэж байгаагүй.	Цахим эрүүл мэнд төслөөр нийлүүлэгдсэн генератор холболт хийгдээгүй. Барилга байхгүй.	No	No	Яаралтай тусламжийн тасагт хучилтөрөгчийн шугамтай Хүүхдийн тасагт хучилтөрөгчийн шугам байхгүй
13	Өмнөговь БОЭТ	БОЭТ-ийн дотрын тасаг мөөгөнцөртсөн.	Цахим эрүүл мэнд төслөөр нийлүүлэгдсэн генератор холболт хийгдээгүй. Барилга байхгүй.			
14	Өвөрхангай БОЭТ	БОЭТ-ийн барилга 1997 онд баригдсан, 5 блок барилгатай, их засвар 1 удаа хийгдсэн. 2013 онд эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн, 2015 онд халдвартын эмнэлгийн өргөтгөл шинээр баригдаж ашиглалтад орсон байна - Лифт байхгүй тул өвчтөнг тээвэрлэхэд хүндрэл бэрхшээлтэй байна.	Цахим эрүүл мэнд төслөөр нийлүүлэгдсэн генератор холболт хийгдээгүй.	Барилгын зарим хэсгүүд газардуулгын системд холбогдсон	Барилгын зарим хэсгүүд агааржуулалтын системд холбогдсон	No
15	Сэлэнгэ НЭ			No	No	No
16	Сүхбаатар НЭ	Төрөх эмнэлгийн барилга – 50 ортой шинээр ашиглалтад орсон боловч тоног төхөөрөмж, тавилга байхгүй	Yes	Барилгын зарим хэсгүүд газардуулгын системд холбогдсон	No	No
17	Төв НЭ					Эрчимт эмчилгээний тасаг, хагалгааны тасагт хучилтөрөгчийн шугамтай

18	Увс НЭ	Халдвартын эмнэлгийн дээврээс ус гоождог	Цахим эрүүл мэнд төслөөр нийлүүлэгдсэн генератор холболт хийгдээгүй.	Физик эмчилгээний тоног төхөөрөмж, СТ зэрэг аппаратуудад газардуулгатай	Yes	No
19	Хэнтий НЭ	1. Нэгдсэн эмнэлгийн барилга шинэ барилга /202 ортой/ - ашиглалтад ороогүй - 2016 оны 12 дугаар сард ашиглалтад орох байсан боловч гүйцэтгэгчээс шалтгаалан хойшлоод байгаа. 2017 оны 1 дүгээр улиралд ашиглалтад орох төлөвлөгөөтэй байгаа. 2. Төрөх, эмэгтэйнчүүдийн тасгийн барилга - Засвар хийх шаардлагатай, сантехник муу - Орон нутгаас 20,0 орчим сая төгрөг төсөвлөсөн боловч хүрэлцэхгүй байгаа тул ЭМЯ-с үлдэгдэл 20,0 сая төгрөг шийдвэрлүүлэх хүсэлтэй байгаа.	Цахим эрүүл мэнд төслөөр нийлүүлэгдсэн генератор холболт хийгдээгүй.	Оношилгооны шинээр баригдаж байгаа төв газардуулгатай	Yes	No
20	Ховд БОЭТ	Нэ-ийн барилга 1976 онд ашиглалтад орсон. Ашиглалтад орсноос хойш засвар үйлчилгээ хийгдээгүй.	Цахим эрүүл мэнд төслөөр нийлүүлэгдсэн генератор холболт хийгдээгүй.	Yes	No	Төрөх эмнэлгийн барилгад хүчилтөрөгчийн шугамтай
21	Хөвсгөл НЭ	Төрөх эмнэлгийн халаалт доголдолтой. Пар байнга хагарч, гагнуур хийгддэг.	Yes	Төрөх эмнэлгийн барилга, СТ гэх мэт тоног төхөөрөмжүүд газардуулгатай	Төрөх эмнэлгийн барилга агааржуулалтын системтэй.	Төрөх эмнэлгийн барилгад хүчилтөрөгчийн шугамтай

Тоног төхөөрөмжийн холбоотой санал, хүсэлт:

Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмжийн хангамжийн байдлыг 2013 оны Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа стандартын дагуу харьцуулж авч үзвэл хангалтгүй байдаг. Тулгамдаж буй асуудлуудыг авч үзвэл:

1. Хэнтий аймаг:

- “Айвико” ХХК –аас 2 ширхэг Гемодиализын аппарат нийлүүлэгдсэн боловч нэг нь ажиллахгүй байгаа.
- 11 аймгийн оношилгооны төвөөр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж баталгаат хугацаа дууссантай холбогдуулан эцсийн үзлэг шалгалт хийлгэх хэрэгтэй байна.
- 2013 онд “Эйч Энд Эйч” ХХК нийлүүлсэн зөөврийн рентген аппаратыг цацрагийн туяа зөвшөөрөгдөх хэмжээнээс их гэж ашиглах зөвшөөрөл олгоогүй.

2. Дорнод аймаг:

- 2008 онд Бельгийн засгийн газрын төсөл хэрэгжсэнээс хойш тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдээгүй тул ихэнх тоног төхөөрөмж элэгдэж, муудсан. Тэр дундаа БОЭТ-ын хувьд Компьютер томорафын аппарат байхгүй нь иргэд Улаанбаатар эсвэл Сүхбаатар аймгагт оношилгоонд орж, хүндрэл учруулж байгаа.
- Лабораторын тасагт 2014 онд “Монгол-Фарм” ХХК –аас нийлүүлэгдсэн Гематологийн аппарат маш их гэмтэл гардаг, ирсэн цагаасаа доголдсон.

3. Сүхбаатар аймаг:

- Нэгдсэн угаалгын тоног төхөөрөмж байхгүй
- 50 ортой төрх эмнэлэг баригдсан тоног төхөөрөмж байхгүй

4. Говьсүмбэр аймаг:

- Fire CR рентген аппарат 2014 онд “Нуган-Трейд” ХХК–с нийлүүлэгдсэн, гэмтэл их гардаг, нурууны зураг муу гардаг.
- Дурангийн мэс заслын 2 эмч бэлтгэгдсэн боловч аппарат байхгүй.

5. Дархан-Уул аймаг:

- Моргийн хөргөгч 2 ажиллаж байгаа тул зуны улирлаас өмнө яаралтай шийдвэрлэх
- Физик эмчилгээний тоног төхөөрөмж
- Флюорографийн аппарат
- Хувийн байгууллагын Компьютер томографийн аппарат түрээсээр байрладаг
- Вакум хагалгааны өрөө

6. Сэлэнгэ аймаг

- Шүдний рентген аппарат – туяаны алдагдал өндөртэй лацдсан.
 - Компьютер томографийн аппарат
 - Усны бохирдол ихтэйгээс аппарат тоног төхөөрөмжийг ажиллагаа доголддог.
7. Орхон аймаг
- Амьсгалын аппарат
 - Тарианы болон дуслын шахуурга
 - Дурангийн хагалгааны камер байнга гацдаг
 - Диализийн усны шүүлтүүрийн мотор байнга шатдаг
8. Хөвсгөл аймаг:
- Хагалгааны гэрэл байхгүйгээс хажуугийн гэрлээр хагалгаа хийгдэж байна.
 - Өвчтөний хяналтын мониторийн хүрэлцээ муу байдаг
 - Түргэн тусламжийн тоноглогдсон автомашинд суурилагдсан дефибрилятор, монитор, зөөврийн амьсгалын аппаратыг яаралтай тусламжийн тасагт хэрэглэж байсан.
9. Булган аймаг:
- Тоног төхөөрөмжийн ашиглалтын болон аюулгүй ажиллагааны сургалт хангалтгүй
 - Хүчилтөрөгч өтгөрүүлэгч, пульсоксиметр, өвчтөний хяналтын монитор дутагдалтай
10. Баян-Өлгий аймаг:
- Хийн систем тавихаар ажиллаж байгаа.
11. Увс аймаг:
- Хятад редуктор резба хурдан алддаг чанаргүй удаан ашиглагдахгүй байна.
 - Өвчтөний хяналтын мониторийн хүүхэд болон нярайд зориулагдсан датчик дутмаг байдгаас аппарат бүрэн ашиглагддаггүй.
12. Төв аймаг:
- Улаанбаатар хоттой газар зүйн байрлалын хувьд ойр болохоор тоног төхөөрөмж нийлүүлэлт бусад аймагтай харьцуулахад муу байдаг.
 - Мэс заслын ор, гэрэл гэх мэт аппаратууд хуучирсан.
13. Дорноговь аймаг:
- 11 оношилгооны төвийн 1 учир сүүлийн үеийн тоног төхөөрөмжүүд нийлэгдэн ажиллаж байна.
14. Дундговь аймаг:
- Улаанбаатар хоттой мөн ойр бөгөөд дутагдалтай тоног төхөөрөмжүүдийг хандив тусламжаар заримыг нь хангуулсан байсан.
15. Өмнөговь аймаг:
- Орон нутгийн хөрөнгө оруулалт сайтай тоног төхөөрөмжүүд сайн байсан.
 - Говийн аймгуудын 1 гол асуудал бол усны чанарын асуудал байна. Усны чанараас шалтгаалан ариутгалын аппаратуудад доголдол их тохиолддог. Тоног төхөөрөмж их нарийн сайн болох тусам мэдрэгч ихтэй алдаа их өгдөг. Ариутгалаас гадна лабораторийн аппаратуудад ус нөлөөлж байна. Тиймээс давхар ус нэрэгч зайлшгүй шаардлагатай байна. Даралтын зөрүүгээс үүдэн мөн алдаа гардаг байна.
16. Говь-Алтай аймаг:
- Тухайн аймгийн онцлогоос шалтгаалан ЭТТ-ийн эвдрэл гардаг. /Говь-Алтай аймгийн ус нь хужир ихтэй тул нэгдсэн эмнэлгийн бүрэн автомат автоклав нь

ажиллахгүй эвдэрсэн байсан. Ус хэрэглэгддэг эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийн ашиглалтын хугацаа богиносж эвдрэл ихтэй байсан./

17. Завхан аймаг:

- Халдварт, сүрьеэгийн тасгийн тоног төхөөрөмж дутмагаас бусад тасгаас тоног төхөөрөмж түр шилжүүлэн авч хэрэглээд буцаан тасагт нь өгөхөд аппаратын дотор талыг нь бүрэн ариутгаж чаддаггүйгээс дахин ашиглахгүй болсон тохиолдол гарсан. /Завхан аймгийн нэгдсэн эмнэлэгт N1H1 халдварт өвчний үед хэрэглэсэн ЭЭЯТ тасгийн амьсгалын аппаратыг ашиглахгүй байсан./

18. Өвөрхангай аймаг:

- Нийтлэгээрээ тог тогтворжуулагч, тог баригч хангалтгүйгээс тог тасрах, хэлбэлзэх үед тоног төхөөрөмж гэмтэж ашиглагдахгүй болсон байсан. Тогны хүчин чадлаас шалтгаалан өндөр хүчин чадлаар ажилладаг аппаратуудыг зэрэг залгах боломжгүйгээс ашиглагдахгүй байсан.
- Ханган нийлүүлэгчдийн ашиглалтын болон засварын сургалт дутуу, чанаргүй хийгддэгээс зарим тоног төхөөрөмжийг үйл ажиллагаанд оруулаагүй байсан. /Ханган нийлүүлэгчид монгол хэл дээрх гарын авлага, зааварчилгааг өгдөггүйгээс эмнэлгийн ажилчид солигдох бүрт тухайн аппаратыг ашиглаж чаддаггүй./

Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмжийг нэгтгэж үзэхэд нийт 26.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна.

Дэлгэрэнгүйг Хавсралт 1. Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаанаас харна уу.

Санхүүжилттэй холбоотой санал, хүсэлт:

- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний сэлбэг хэрэгслийн төсөв байдаггүй.
- Сумын эмнэлгүүдийн холын дуудлагад явах шатахууны төсөв хангалтгүй, хүрэлцдэггүй.

Автомашин:

- Автомашины засвар үйлчилгээний төсөв байдаггүй тул машиныг цаг тухайд нь засвар үйлчилгээ хийлгэж чаддаггүй энэ нь насжилтыг багасгах үндсэн шалтгаан болдог.

Эм, эмнэлгийн хэрэгсэл:

- Эм тариаг тендерээр нийлүүлж байгаа компани цаг хугацаандаа нийлүүлдэггүй.

Бүтэц орон тоо:

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны үндэс суурь нь тухайн тоног төхөөрөмжийг хариуцсан ажилладаг эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер техникийн ажилчид байдаг ба Эрүүл мэндийн сайдын 2006 оны 439 дугаартай “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер техникчдийн бүрэлдэхүүний бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага батлах тухай” тушаалын дагуу 21 аймгийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг болон Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд ажиллаж буй инженер, техникчдын судалгаа хийсэн.

Хүснэгт.1 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникчдын тоо

№	Аймаг	Тоног төхөөрөмжийн тоо	Тушаалын дагуу ажиллах орон тоо	Албатай эсэх	Ажиллаж буй орон тоо		Ажлын өрөө	Засварын өрөө	Ажлын багаж, туслах хэрэгслийн хангалт
					ЭМГ	НЭ			
1	Архангай НЭ	430	4 инженер, 1 техникч	-	1 мэргэжилтэн /Санхүү/	2 ЭТТ инженер	+	-	-
2	Баянхонгор НЭ	334	3 инженер, 1 техникч	-	1 мэргэжилтэн /Эмзүйч/	1 ЭТТ инженер	+	-	-
3	Булган НЭ	430	3 инженер, 1 техникч	-	1 мэргэжилтэн /IT инженер/	1 ЭТТ инженер	+	-	-
4	Баян-Өлгий НЭ	450	3 инженер, 1 техникч	-	1 мэргэжилтэн /Эмзүйч/	1 ЭТТ инженер			
5	Говь-Алтай НЭ	428	4 инженер, 1 техникч	+	1 мэргэжилтэн /Барилгын инженер/	1 ЭТТ инженер 1 техникч	+	-	-
6	Говьсүмбэр НЭ	348	3 инженер, 1 техникч	-	1 мэргэжилтэн / IT инженер /	1 ЭТТ инженер			
7	Дархан-Уул	695	6 инженер, 2 техникч		1 мэргэжилтэн /Эмзүйч/	1 ЭТТ инженер 1 ХХ-ын инженер	+	-	-
8	Дорнод	1171	11 инженер, 3техникч	-	1 мэргэжилтэн / эмч /	1 ЭТТ инженер 1 IT инженер 1 Электроник инженер 1 техникч			
9	Дорноговь	433	4 инженер, 1 техникч	-	1 мэргэжилтэн / эм зүйч /	1 ЭТТ инженер			
10	Дундговь	427	4 инженер, 1 техникч	-	1 мэргэжилтэн / эм зүйч /	1 ЭТТ инженер			
11	Завхан	512	5 инженер, 1 техникч	-	1 мэргэжилтэн /Эмзүйч/	1 ЭТТ инженер	+	+	-
12	Орхон	380	3 инженер, 1 техникч	-	1 мэргэжилтэн /Санхүү/	1 ЭТТ инженер	+	-	-
13	Өмнөговь	480	4 инженер, 1 техникч	-	1 мэргэжилтэн / эм зүйч /	1 ЭТТ инженер	+	-	-
14	Өвөрхангай	795	7 инженер, 2 техникч	-	1 ЭТТ инженер	1 ЭТТ инженер 1 техникч	+	-	-
15	Сэлэнгэ	385	3 инженер, 1 техникч	-	1 мэргэжилтэн /Санхүү/	1 техникч	-	-	-
16	Сүхбаатар	480	4 инженер, 1 техникч	-	1 мэргэжилтэн / эм зүйч /	1 ЭТТ инженер 1 техникч	+	-	-
17	Төв		3 инженер, 1 техникч	-	1 мэргэжилтэн / эм зүйч /	1 ЭТТ инженер	+	-	-
18	Увс	580	3 инженер, 1 техникч	-	1 мэргэжилтэн / эм зүйч /	1 ЭТТ инженер	+	-	-
19	Хэнтий	368	3 инженер, 1 техникч	-	1 мэргэжилтэн / эм зүйч /	1 ЭТТ инженер	+	-	-
20	Ховд		3 инженер, 1 техникч	-	1 мэргэжилтэн / эм зүйч /	1 ЭТТ инженер	+	-	-
21	Хөвсгөл	595	5 инженер, 2 техникч	-	1 мэргэжилтэн /IT инженер/	2 ЭТТ инженер 1 IT инженер	+	-	-

Энэхүү тушаалын хэрэгжилт бүх аймгуудад хангалтгүй байна. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба байхгүй, орон тоогоор хангагдаагүй тул ачаалал ихтэй ажилладаг. Мөн эмнэлгийн тоног төхөөрөмж засварлах өрөө байхгүй, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдийн ажиллах орчин шаардлага хангахгүй. Жич: сууж буй өрөө нь коридорын хэсгийг өрөө болгож гаргасан, зориулалтын өрөө биш, угаалтуур, агааржуулагч, зориулалтын ширээ сандал, принтер байхгүй гэх мэт нийтлэг дутагдлууд байна.

Орон тоогоор ажилладаггүй мөн ажлын өрөө болон засварын өрөө хангалтгүй, компьютер интернетээр хангагдаагүй, засварын багаж хэрэгсэл дутмаг байгаа нь эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай үйл ажиллагааг ханган ажиллах болон бусад шаардлагатай судалгаа, тайлан мэдээ гаргах үйл ажиллагаа удаашралтай, хөрөнгийн төлөвлөлт, баримт бичгийн бүрдэл хангалтгүй байна. Шаардлагатай сэлбэг хэрэгслийн нөөц мөн хангалтгүй байна.

Зорилт 2. Эрүүл мэндийн байгууллагуудад илүүдэлтэй байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжүүдтэй газар дээр нь танилцаж, шилжүүлэх арга хэмжээ авах

Эрүүл мэндийн яамнаас 2016 оны 8 дугаар сард илүүдэлтэй болон ашиглагдахгүй байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгаа авсан ба судалгааны дагуу газар дээр нь тухайн илүүдэлтэй байгаа тоног төхөөрөмжийн үйл ажиллагаатай танилцаж, шилжүүлэн ашиглах боломжийг судлан үзлээ.

Хүснэгт. 2 Илүүдэлтэй тоног төхөөрөмж болон шилжүүлэн ашиглах боломжтой тоног төхөөрөмжийн мэдээлэл

№	Аймаг	Илүүдэлтэй тоног төхөөрөмж		Цаашид ашиглах боломжтой шилжүүлэх боломжтой тоног төхөөрөмж	
		Тоо	Төрөл	Тоо /төрөл	Тайлбар
1	Архангай НЭ	1	Биохимийн хагас автомат анализатор	Биохимийн хагас автомат анализатор - 1 ш.	Эрдэнэмандал сумд байдаг боловч хэрэглэх шаардлага гардаггүй. /Шинэ/
2	Баянхонгор НЭ	байхгүй			
3	Булган НЭ	байхгүй			
4	Баян-Өлгий НЭ	байхгүй			
5	Говь-Алтай НЭ	байхгүй			
6	Говьсүмбэр НЭ	5	УВЧ аппарат Утлагын аппарат - 2 ш Микроскоп Флюр		
7	Дархан-Уул	5	Биохимийн анализатор хуурай Колон тоологч Биохимийн анализатор Бүлэгнэлтийн бүрэн автомат анализатор Тариурын автомат шахуурга	5	Лабораторийн 4 тоног төхөөрөмжийн ажиллагаа хэвийн боловч ашиглагддаггүй, уусмалын асуудлаа шийдвэрлэвэл өөрийн эмнэлэгт ашиглах боломжтой. Тариурын автомат шахуургад таарах тариур олддоггүй
8	Дорнод БОЭТ	2	Шүдний рентген аппарат Ус нэрэгч		

9	Дорноговь	байхгүй			
10	Дундговь	байхгүй			
11	Завхан	1	Эдийн бүрэн автомат анализатор	Эдийн бүрэн автомат анализатор - 1ш.	Ажиллагаа хэвийн. Шилжүүлэн ашиглах боломжтой. Эдийн бүрэн автомат анализатор өдөрт 300 хүн үзэх хүчин чадалтай тул ашиглах боломж гардаггүй. Огт ашигладаггүй. Оронд нь микроном хэрэгтэй. Эдийн шинжилгээг хотруу явуулж шинжлүүлдэг.
12	Орхон	6	Центрофуг Отсос Шээсний анализатор Поток Автомат пипетка		
13	Өмнөговь	байхгүй			
14	Өвөрхангай	байхгүй			
15	Сэлэнгэ	байхгүй	Нэгдсэн эмнэлэгт илүүдэлтэй тоног төхөөрөмж байхгүй. Алтанбулаг суманд Чих хамар хоолойн аппарат, нүдний угийн дуран ашиглагддаггүй.	Чих хамар хоолойн аппарат - 1 ш нүдний угийн дуран - 1ш	Нарийн мэргэжлийн эмч бэлтгэгдээгүй учир ажиллагаанд оруулаагүй. Эмч мэргэжилтэн бэлтгэсэн газар шилжүүлэх
16	Сүхбаатар	3	Биохимийн анализатор Гематологийн анализатори Шээсний анализатори		
17	Төв	3	Рентген аппарат Автоклав - 2 ш /LAS6305/	Ажиллагаа доголдолтой байгаа тул засвар үйлчилгээ хийгдсэний дараагаар шилжүүлэх боломжтой.	
18	Увс	байхгүй			
19	Хэнтий	2	Амьсгалын аппарат - 2 ш /том хүн, хүүхэд/		
20	Ховд	байхгүй			
21	Хөвсгөл Хөвсгөл	1	Амьсгал дэмжигч	Амьсгал дэмжигч аппарат - 1 ш /Bipap /	Ажиллагаа хэвийн. Шилжүүлэн ашиглах боломжтой.
		1	Угаалгын машин 1	Амьсгал дэмжигч аппарат - 1 ш /Bipap /	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар авсан боловч ашигладаггүй удсан учраас ажиллагаа доголдсон

Аймгийн эрүүл мэндийн байгууллагууд илүүдэлтэй болон ашиглагдахгүй тоног төхөөрөмжийн судалгаа ирүүлэхдээ цаашид ашиглах боломжгүй, актлагдах тоног төхөөрөмжийг оруулан ирүүлсэн нь илүүдэлтэй тоног төхөөрөмж их байгаа мэт харагдаж байгаа боловч, газар дээр нь тухайн судалгаанд ирүүлсэн тоног төхөөрөмжөөс цаашид ашиглагдах боломжтой тоног төхөөрөмжийн тоо бага байна.

Нийт 5 нэр төрлийн тоног төхөөрөмжийн хэрэгцээтэй газар нь шилжүүлэн ашиглах боломжтой байна.

Дээрх илүүдэлтэй байгаа тоног төхөөрөмжөөс гадна ашиглагдахгүй байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжүүд нь дараах шалтгааны улмаас ашиглагддаггүй байна.

- Урвалж оношлуурууд нийлүүлэгддэггүй. Өртөг өндөртэй, хаалттай системтэй /тохирсон урвалж олдоцгүй
- Дагалдах хэрэгсэл дутуу. Анх ханган нийлүүлэгчдээс дагалдаж ирдэггүй, ирсэн ч цөөн тоогоор ирээд дуусчихдаг, дахин худалдах авахад өртөг өндөр, эрүүл мэндийн байгууллагын төсөв хүрэлцдэггүй.
- Ашиглалтын хугацаа дууссанаас шалтгаалан аппарат үйлдвэрлэгдэхээ больсон учир дагалдах хэрэгсэл, сэлбэг олддоггүй.

Зорилт 3. Эрүүл мэндийн байгууллагуудын эвдрэл гэмтэлтэй байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгаа гаргаж, засварлах боломжтой тоног төхөөрөмжийг газар дээр нь хэвийн үйл ажиллагаанд оруулах

Энэхүү ажлын хэсэгт Эрүүл мэндийн яамны харьяа төв эмнэлгүүдээс эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хариуцан ажилладаг чадварлаг инженерүүд баг тус бүрт явсан ба томилолтоор ажилласан аймгуудын гэмтэлтэй тоног төхөөрөмжтэй танилцаж, боломжит засвар үйлчилгээг тухай бүр гүйцэтгэгч, заавар зөвлөмж өгч ажилласан.

Хүснэгт.3. Засвар үйлчилгээ хийгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж

№	Аймаг	Зассан тоног төхөөрөмж		Оношилсон тоног төхөөрөмж	
		тоо	нэр	тоо	нэр
1	Архангай НЭ	3	Нярайн дулаацуулагч, Инкубатор 2,	2	Эхо аппарат, Амьсгалын аппарат, Шаралгын аппарат
2	Баянхонгор НЭ	10	Хүчилтөрөгч өтгөрүүлэгч 3, Пульсоксиметр, Дуслын шахуурга, Мэс заслын цахилгаан хутга 2, Нярайн дулаацуулах ширээ, Унтуулгын аппарат, Өвчтөний хяналтын монитор	10	Зөөврийн эхо, УВЧ-66, Нярайн дулаацуулагч, Өвчтөний хяналтын монитор 6 ширхэг, ЭКГ аппарат, Суурин эхо ЭМГ 2
3	Булган НЭ	4	Коагуляцын аппарат, Цус бүлэгнэлтийн апаарат, Дефибрилятор, ЭКГ		
4	Баян-Өлгий НЭ	5	Вакцины хөргөгч	1	Вакцины хөргөгч
5	Говь-Алтай НЭ	5	Дезкамер, Суурин эхо, Хүчилтөрөгч өтгөрүүлэгч 2, Автоклав ВК-75	10	Shinva автоклав, Угаалгын машин, Автомат угаагч, Автоклав 250литр, Шүдний суурин БОР, Хүчилтөрөгч өтгөрүүлэгч 2, Тариурын шахуурга, Нярайн амьсгалын аппарат, ЭКГ Bioscare ECG-101G
6	Говьсүмбэр НЭ	15	Ургын монитор 3, Хүчилтөрөгч өтгөрүүлэгч 3, тариурын шахуурга 3, ЭКГ 2, Амьсгалын аппарат, Уян дуран, Зөөврийн кварц, Нярайн инкубатор, Утлагын аппарат, Отсос	2	Амьсгалын аппарат, Уян дуран
7	Дархан-Уул НЭ	4	УВЧ 3, Утлагын аппарат	1	C- Arm
8	Дорнод БОЭТ	2	Өвчтөний хяналтын монитор, Автоклав	4	Бүрэн автомат автоклав, Оношилгооны уян дуран, Гематологийн анализатор, СТ

9	Дорноговь НЭ	15	Автоклав /дурангийн /, Термостат, Татлагын ор, Эмийнхөргөгч, Колькоскопи, өвчтөний хяналтын монитор 2, Коагуляцын аппарат 2	3	Иммунологийн бүрэн автомат анализатор, Биохимийн бүрэн автоматанализатор, Зүрхний ЭХО,
10	Дундговь НЭ	17	ЭХО LOGIQ A1, ЭХО DUS6, Нярайн инкубатор, Фото аппарат , Нярайн дулаацуулах ширээ, Хүчилтөрөгч өтгөрүүлэгч, УВЧ-30, УВЧ-66 4 ширхэг, Шүдний кресиль, Ус нэрэгч , Автоклав-4 ш	4	Зөөврийн хүчилтөрөгч өтгөрүүлэгч, Хүчилтөрөгч өтгөрүүлэгч, Нярайн дулаацуулах ширээ, Коагуляци
11	Завхан НЭ	13	Хүчилтөрөгч өтгөрүүлэгч 3, Ширээний автоклав, Утлагын аппарат 4, Эхо аппарат, Отсос, Кварц, ЭКГ, УВЧ	5	Эхо аппарат, Пульсоксиметр, Уушигны багтаамж хэмжигч, Биохимийн анализатор
12	Орхон БОЭТ	7	Дурангийн дүрс хувиргагч, Дуслын шахуурга, Тарианы шахуурга, Инкубатор, Ус цэвэршүүлэгч, Кольпоскоп, Коагуляцын аппарат	2	Коагуляцын аппарат, Дуслын шахуурга.
13	Өмнөговь БОЭТ	15	Өвчтөний хяналтын монитор, Коагуляцын аппарат, токографи, УВЧ 4 ширхэг, Дулаацуулах ширээ 2, тог баригч, Автоклав, Ургын зүрхний бичлэгийн аппарат, ЭКГ, ЭХО.	2	унтуулгын аппарат, унтуулгын аппарат аеоп
14	Өвөрхангай БОЭТ	16	Духны гэрэл, Ус нэрэгч, Дефибрилятор, Өвчтөний хяналтын монитор, Амьсгалын аппарат, Дурангийн гэрэл үүсгэгч, Цусны хөргөгч, Ширээний автоклав, Ломбо хатууруулагч	7	Бүрэн автомат автоклав, Даралтын аппарат /автомат/, Уурын индүү, Эхо аппаратын принтер, Отсос, Мэс заслын цахилгаан хутга, Луч
15	Сэлэнгэ НЭ	6	Дуслын автомат шахуурга, тарианы автомат шахуурга, ЭХО, Ургын монитор, Лорын аппарат, Хагалгааны гэрэл	1	Суурин Рентген аппарат
16	Сүхбаатар НЭ	4	Ургын хяналтын монитор, ургын доплер, Пульсоксиметр, Коагуляцын аппарат,	1	Амьсгалын аппарат
17	Төв НЭ	13	Автоклав 5, Нярайн дулаацуулагч ширээ, Хатаах шүүгээ 2, Автомат дуслын шахуурга 2, УВЧ, Салиа соруулагч аппарат, Хүчилтөрөгч өтгөрүүлэгч -аппарат, Шарлагын аппарат 2.	1	Флюорографи
18	Увс НЭ	4	Зөөврийн автоклав, Дулаацуулах ширээ, Вакцины хөргөгч, УВЧ 30	1	УВЧ 80
19	Хэнтий НЭ	10	Өвчтөний хяналтын монитор, Лазер аппарат, Автомат даралтын аппарат, УВЧ-80, Утлагын аппарат, Гематологийн анализатор, Хагалгааны дуран, Поток, Шарлагын аппарат, УВЧ 66,	2	Хагалгааны дуран, Лазер аппарат
20	Ховд БОЭТ	3	Амьсгалын аппарат, Хүчилтөрөгч өтгөрүүлэгч, негатоскоп	1	Хальс уншигч негатоскоп

21	Хөвсгөл НЭ	9	Отсос, дуслын шахуурга, инкубатор, ЭКГ, ЭЭГ, Диаликын аппарат4	4	Диализын аппарат
Нийт		180		52	



Зураг 6. ЭТТ-ийн засвар үйлчилгээний мэргэжлийн инженерээс бүрдсэн баг



Зураг 7. Г.Буянхүү – ЭХЭМҮТ-ийн ЭТТ-ийн инженер – I баг



Зураг 8. А.Баянмөнх – ГССҮТ-ийн ЭТТ-ийн техникч - II баг



Зураг 9. Н.Наранбаатар – ХӨСҮТ-ийн ЭТТ-ийн инженер – III баг



Зураг 10. Ж.Ганбат – УНТЭ-ийн ЭТТ-ийн инженер – IV баг



Зураг 11. Ц.Ганбат – Улаанбаатар төмөр замын НЭ-ийн ЭТТ-ийн инженер – V баг

5 багт ажилласан эмнэлгийн тоног төхөөрөмжийн 5 инженерүүд 21 аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгооны эмчилгээний төвийн гэмтэлтэй байсан 180 тоног төхөөрөмжийг газар дээр нь завсарлан хэвийн үйл ажиллагаанд оруулж, 52 тоног төхөөрөмжийн гэмтлийг оношилсон байна.

Дэлгэрэнгүйг Хавсралт 2. Засвар үйлчилгээний тайлангаас харна уу.

Зорилт 4. Засвар үйлчилгээнд шаардлагатай сэлбэг хэрэгсэл, төсвийг гаргаж, нэгдсэн байдлаар шийдвэрлэх

Тухайн газар дээр нь засварлах боломжгүй тоног төхөөрөмжийн гэмтлийг оношилж, тэдгээрт шаардлагатай сэлбэг хэрэгслийн тооцоог гаргалаа.

Хүснэгт. 4. Гэмтэлтэй тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд шаардлагатай сэлбэг хэрэгслийн тооцоо

№	Аймгийн нэр	Шаардлагатай санхүүжилт
1	Архангай	35,283,000.00
2	Баянхонгор	2,478,000.00
3	Баян-Өлгий	4,500,000.00
4	Булган	3,420,000.00
5	Говь-Алтай	11,340,000.00
6	Говь-Сүмбэр	3,050,000.00
7	Дундговь	11,000,000.00
8	Дархан	13,435,000.00
9	Дорноговь	5,746,000.00
10	Дорнод	92,091,150.00
11	Завхан	5,000,000.00
12	Орхон	5,000,000.00
13	Өвөрхангай	12,441,700.00
14	Өмнөговь	17,362,400.00
15	Сүхбаатар	3,500,000.00
16	Сэлэнгэ	4,000,000.00
17	Төв	34,528,500.00
18	Увс	68,370,000.00
19	Ховд	54,700,000.00
20	Хөвсгөл	21,684,500.00
21	Хэнтий	25,696,060.00
		434,626,310.00

21 аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний сэлбэг хэрэгсэлд 434,6 сая төгрөг шаардлагатай байна.

Энэхүү шаардлагатай санхүүжилтэд тухайн эмнэлгийн тоног төхөөрөмжийг хэвийн найдвартай ажиллуулахад шаардагдах хугацаат сэлбэг хэрэгслийн үнэ орсон болно.

Зорилт 5. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга хийх

Монгол улсын Шадар сайдын 2015 оны 117 дугаартай “Хэмжил зүйн ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” тушаал, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 249 дугаартай “Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх журам” тушаалын дагуу аймгийн нэгдсэн эмнэлэг болон бүсийн оношилгоо, эмчилгээний төвд ашиглагдаж байгаа шалгалт тохируулгад хамрагдах шаардлагатай тоног төхөөрөмжүүдэд шалгалт тохируулгыг Эрүүл мэндийн сайдаас өгсөн чиглэлийн дагуу үнэ төлбөргүй хийж гүйцэтгэсэн.

Эрүүл мэндийн хөгжлийн Мэдээллийн технологи, эмнэлгийн тоног төхөөрөмжийн албанд эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга хийх нийт 11 анализатор, симулятор байдаг бөгөөд 2016 оны хувьд Герман улсад чанарын баталгаажилт хийгдсэн 4 нэр төрлийн (ANSUR Automated Prosim8 маркийн Өвчтөний хяналтын монитор шалгах симулятор, ANSUR Automated QA-ES Series II маркийн Цахилгаан мэс

заслын аппарат шалгах тест анализатор, Impulse 7000DP маркийн Дефибрилляторын шалгах тест анализатор) анализатор, симулятороор шалгалт тохируулга хийгдэж байсан.

Энэхүү ажлын хэсгийн хүрээнд шалгалт тохируулга хийх эмнэлгийн тоног төхөөрөмжийг нэр төрлийн нэмэгдүүлж, INCU™ маркийн Нярайн инкубатор шалгах анализатор, IDA 4 Plus маркийн Дуслын болон тариурын автомат шахуурга шалгах анализатор, General purpose urethane 84-342 маркийн Хэт авиан оношилгооны аппарат шалгах фантом-аар туршилтын шалгалт тохируулга хийж гүйцэтгэсэн.

Хүснэгт 5. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга хийх анализатор болон симуляторын хувиарлалт

№	Аймаг	Хариуцах мэргэжилтэн	Шалгалт тохируулга хийх анализатор болон симулятор	Шалгалт тохируулгад хамрагдах эмнэлгийн тоног төхөөрөмж
1.	Хэнтий Дорнод Сүхбаатар Говьсүмбэр	Б.Батцэнгэл	1. Өвчтөний хяналтын монитор шалгах симулятор 2. Цахилгаан мэс заслын аппарат шалгах тест анализатор 3. Хэт авиан оношилгооны аппарат шалгах фантом	1. Өвчтөний хяналтын монитор 2. Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат 3. Цахилгаан мэс заслын аппарат 4. Хэт авиан оношилгооны аппарат
2.	Дархан-Уул Сэлэнгэ Орхон Булган Хөвсгөл	Б.Сансармаа	1. Нярайн инкубатор шалгах тест анализатор 2. Дуслын болон тариурын автомат шахуурга шалгах тест анализатор	1. Дуслын автомат шахуурга 2. Тариурын автомат шахуурга 3. Нярайн инкубатор
3.	Увс Баян-Өлгий Ховд	Б.Санж-Очир	1. Дефибрилляторын шалгах тест анализатор 2. Нярайн инкубатор шалгах тест анализатор	1. Дефибриллятор 2. Нярайн дулаацуулах ширээ 3. Нярайн инкубатор
4.	Төв Дундговь Өмнөговь Дорноговь	Ц.Уянга	1. Цахилгаан мэс заслын аппарат шалгах тест анализатор 2. Дефибрилляторын шалгах тест анализатор	1. Цахилгаан мэс заслын аппарат 2. Дефибриллятор
5.	Өвөрхангай Баянхонгор Завхан Архангай Говь-Алтай	Б.Батцоож	1. Өвчтөний хяналтын монитор шалгах симулятор 2. Хэт авиан оношилгооны аппарат шалгах фантом	1. Өвчтөний хяналтын монитор 2. Хэт авиан оношилгооны аппарат



Зураг 11. Б.Батцэнгэл – ЭМХТ-ийн мэргэжилтэн – Өвчтөний хяналтын монитор шалгаж байна – I баг




Зураг 12. Б.Сансармаа – ЭМХТ-ийн ахлах мэргэжилтэн - Инкубатор шалгаж байна – II баг



Зураг 13. Б.Санж-Очир – ЭМХТ-ийн ахлах мэргэжилтэн – Дефибрилятор шалгаж байна – III баг



Зураг 14. Ц.Уянга – ЭМХТ-ийн мэргэжилтэн – Дефибрилятор шалгаж байна – IV баг



Зураг 15. Б.Батцоож – ЭМХТ-ийн мэргэжилтэн – Өвчтөний хяналтын монитор шалгаж байна – V баг

Хүснэгт 6.Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга хийсэн эмнэлгийн тоног төхөөрөмж

№	Аймаг	1.Өвчтөний хяналтын монитор		2. Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат		3.Хэт авиан оношилгооны аппарат		4. Цахилгаан мэс заслын аппарат		5. Дефибрилятор шахуурга		5. Дуслын автомат шахуурга		6. Тарианы автомат шахуурга		7. Нярайн инкубатор		8. Нярайн дулаацуулах ширээ		НИЙТ ДҮН	
		Нийт	Тэнцээгүй	Нийт	Тэнцээгүй	Нийт	Тэнцээгүй	Нийт	Тэнцээгүй	Нийт	Тэнцээгүй	Нийт	Тэнцээгүй	Нийт	Тэнцээгүй	Нийт	Тэнцээгүй	Нийт	Тэнцээгүй	Нийт	Тэнцээгүй
1	Архангай НЭ	3	3																	3	3
2	Баянхонгор НЭ	2	1	2	0															4	1
3	Булган НЭ											7	5	5	3	6	1			18	9
4	Баян-Өлгий НЭ									3	1					4	1	5	0	12	2
5	Говь-Алтай НЭ	7	6	3	0															10	6
6	Говьсүмбэр НЭ	11	9	6	3	5	0	2	2											24	14
7	Дархан-Уул											2	0	4	0	1	0			7	0
8	Дорнод БОЭТ	3	3	4	0	4	0	3	2											14	5
9	Дорноговь НЭ							2	1	2	0									4	1
10	Дундговь НЭ							3	2											3	2
11	Завхан НЭ	8	8	7	0															15	8
12	Орхон БОЭТ											7	2	4	1	2	0			13	3
13	Өмнөговь БОЭТ							4	3											7	3
14	Өвөрхангай НЭ	6	6	1	0															7	6
15	Сэлэнгэ НЭ											5	0	3	0	1	0			9	0
16	Сүхбаатар НЭ	13	12			3	0	3	3											19	15
17	Төв НЭ							2	1											2	1
18	Увс НЭ									3	1					4	1	5	0	12	2
19	Хэнтий НЭ	11	11	2	0	2	0	2	2											17	13
20	Ховд НЭ									5	1					4	0	3	0	12	1
21	Хөвсгөл НЭ											9	6	4	1	2	0			15	7
		64	59	25	3	14	0	21	16	13	3	30	13	20	5	24	3	13	0	224	102

Нийт 8 төрлийн тоног төхөөрөмжийн 224 ширхэг тоног төхөөрөмжид 12,1сая төгрөгийн өртөгтэй шалгалт тохируулгын ажил хийж гүйцэтгэсэн ба үүнээс шаардлага нийцсэн 122 тоног төхөөрөмж, нийцээгүй тоног төхөөрөмж 102 байгаа бөгөөд шаардлага хангасан тоног төхөөрөмж 45,5%-тай байна.

График. 1.Шалгалт тохируулга хийгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэр төрөл



Дэлгэрэнгүйг Хавсралт 3. Шалгалт тохируулгын нэгдсэн тайлангаас харна уу.

Зорилт 6. 11 аймагт байгуулагдсан “Оношилгооны төв”-үүдэд нийлүүлэгдсэн эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн баталгаат хугацаа дуусаж байгаатай холбогдуулж тоног төхөөрөмжийн ашиглалтын байдалтай танилцах, цаашид хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай тооцоо судалгааг гаргах

2013-2014 онд Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний “Эрүүл чийрэг монгол хүн” хөтөлбөрийн “Эх орондоо чанартай оношилгоо, эмчилгээ хийлгэх боломжийг бүрдүүлэх” 165 дугаар зорилтын хүрээнд 11 аймагт Ерөнхий сайдын хөрөнгө оруулалтын багцын төсвийн хөрөнгөөс “Оношилгооны төв” байгуулахаар шийдвэрлэн 11 аймагт 15-24 нэр төрлийн нийт 19,2 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангасан. Мөн тухайн аймгийн оношилгооны төвийн барилгын засвар, тоног төхөөрөмжийн өрөөний засварт 2,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн.

Энэхүү хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн ашиглалтын нөхцөл байдалтай танилцаж, 2014-2016 онд тухайн тоног төхөөрөмжөөр оношилгоо, шинжилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоог гаргасан.

“Оношилгооны төв” төслийн хүрээнд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжүүдээс ашиглалтын хувьд доголдсон, сэлбэг хэрэгсэл хүн хүч шаардлагатай байгаа тоног төхөөрөмжүүдийг аймаг тус бүрээр дурдвал:

*Хүснэгт 7. Оношилгоо, эмчилгээ хийсэн тоо
(тоног төхөөрөмжийн нэр төрлөөр)*

№	Тоног төхөөрөмжийн нэр төрөл	Үйлчлүүлэгчийн тоо
1	Компьютер томографи	6096
2	Дурангийн тоног төхөөрөмжүүд	7,183
3	Дижитал ЭХО аппарат	184,670
4	Тархины судасны доплерографи	184670
5	Нүдний тоног төхөөрөмжүүд	228,417
6	Чих, хамар, хоолойн тоног төхөөрөмжүүд	113,352
7	Шүдний тоног төхөөрөмжүүд	39,582
8	Лабораторийн тоног төхөөрөмжүүд	1,795,940
9	Рентген тоног төхөөрөмж	557
НИЙТ ДҮН		2,258,879

**Хүснэгт 7. Оношилгоо, эмчилгээний тоо
(2014-2016 он, тоног аймгаар)**

№	Тоног төхөөрөмж	Марк	Үйлдвэрлэсэн улс	Архангай	Баян-Өлгий	Баянхонгор	Говь-Алтай	Дорноговь	Завхан	Сүхбаатар	Сэлэнгэ	Увс	Хөвсгөл	Хэнтий	Нийт тоо
1	Компьютер томограф	Somatom Emotion 16	ХБНГУ		32		99	46	20	22		54	30		303
2	Ходоодны дурангийн иж бүрдэл	Fujinon EG-530WR	Япон			4		62	68	86	182	195	148	153	898
3	Уушигны видео дуран	Fujinon EB-530S	Япон					0	2	0		130	0	1	133
4	Бүдүүн гэдэсний дурангийн иж бүрдэл	Fujinon EC-530WM	Япон			0		0	3	0		130	0	25	158
5	Урологийн дурангийн иж бүрдэл	Fujinon EY-470SB	Япон			0		0	0	0		50	0	2	52
6	Дуран угаагч, ариутгах төхөөрөмж	CYW-100	БНСУ			4		62	0	86			148	181	481
7	Дижитал ЭХО аппарат	UGEO H60	БНСУ	1287	2500	256	465	1674	1360	572	1530	1365	195	1025	12229
8	Тархины судасны доплерографи	Delica 9UA	ХБНГУ			313		15	0	0	4	0	11	32	375
9	Авторефрактометр	CRK-7000	БНСУ	46	350	200			23	20	50	700	400	120	1909
10	Хялар тодорхойлох багажны иж бүрдэл	Trial lens set 226pcs	БНХАУ		950	250			11	180	65	700	0		2156
11	Харааны талбай хэмжигч багаж	AP-5000C	Япон						9	0		5	10		24
12	Нүдний даралт хэмжигч	HT-5000	БНСУ		720	300				0		0	0		1020
13	Завсрын ламп /биомикроскоп/	Slit lamp YZ5 XI	БНХАУ	835	1025	1076				1100		1050	500		5586
14	Диоптриметр	TL-100	Япон	21	210	0			27	15	9	350	110	30	772
15	Чихний сонсгол шалгах автомат аппарат	Audiometer	Итали	786		863			27	83		78	42	27	1906
16	Чихний сонсгол бичих кабинет	33660	Итали	12							1215	78	42	27	1374
17	Чих, хамар, хоолойн эмчилгээ, оношлогооны ширээ	INU-5000	БНСУ						454	2296		645	605	1224	5224
18	Шүдний суурин машины иж бүрдэл	HY-2288-C9A	БНХАУ					1557		910	1118	1260	0	964	5809
19	Шүдний дэлгэмэл рентген аппарат	Papaya	БНСУ			0	10	21	20	26	37	225	0	210	549
20	Биохимийн анализатор	Cobas c311	ХБНГУ	762	620	2132	845	456	396	75	2589	800	1500	278	10453
21	Гематологийн анализатор	Pentra ES60	Франц	720				216	345	588	901	13	3269	625	6677
22	Коагулаграммийн анализатор	Sta compact	Франц	368		0		18		29	53		100	54	622
23	Шээсний анализатор	UriSet2	ХБНГУ	150	80	0		97	78	0	1579	140	1	100	2225
24	Илиза уншигч	Cobas c411	ХБНГУ	66		0		23	0	0			200	425	714
25	Рентген зургийг дижитал болгон хувиргагч төхөөрөмж	Fire CR+80	БНСУ		115				7	5		472	0	100	699
26	Рентген суурин дижитал төхөөрөмж	Bellagio 630	БНСУ			458	85				45	472	0		1060
	ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БҮГД			5053	6602	5856	1504	4247	2850	6093	9377	8912	7311	5,603	63408

Хүснэгт 9. Оношилгооны төвд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн ашиглалтын явцад үүссэн гэмтэл, засварлагдсан байдал, гэмтэл үүсэх магадлал

№	Аймгийн нэр	Тоног төхөөрөмжийн нэр	Тоног төхөөрөмжийн доголдолын шалтгаан	Ханган нийлүүлэгч
1	Говь-Алтай НЭ	Компьютер томографийн аппарат	Шётка нь элэгдэж 2 мм үлдсэн Рентген хоолой солих шаардлагатай CD уншигч нь эвдэрсэн	Моносфарм трейд ХХК
2	Завхан НЭ Баян-Өлгий НЭ	Компьютер томографийн аппарат	Шётка нь элэгдэж 2 мм үлдсэн	Моносфарм трейд ХХК
2	Говь-Алтай НЭ	Шүдний дэлгэмэл рентген	Зориулалтын бус эмч нарын өрөөнд байрлуулсан, хавчиг нь хугарсан, програм устсан, детектор нь эвдэрсэн тул ашиглагдахгүй	Чоногол трейд ХХК
3	Сэлэнгэ НЭ	Чих сонсгол шалгах автомат аппарат	2016 оноос хойш ажиллахгүй байгаа. Программ гацаж үйлдлээ	Чоногол трейд ХХК

			хийдэггүй. Гараараа бодолт хийж оношилгоо хийж байгаа. Ханган нийлүүлэх компанид хандаад нь мэддэггүй.	
4	Сэлэнгэ НЭ	Чих хамар хоолойн оношилгооны ширээ	Үзлэгийн гэрлийн ламп болон кварцын ламп шатсан. Олдоц муутай. Компрессорын хүчин чадал муу тул эмчилгээ хийх боломжгүй.	Чоногол трейд ХХК
5	Сэлэнгэ НЭ	Нүдний даралт хэмжигч Тонометр	Дагалдагч суурьгүй ирсэн учраас ашиглагдах боломжгүй. Сууринд шаардлагатай “Слит ламп” аппарат байдаггүй.	Чоногол трейд ХХК
6	Сэлэнгэ НЭ	Ходоодны дурангийн иж бүрдэл	Ашиглалтын явцад 1 удаа гэмтсэн. Ханган нийлүүлэгч компани засварлаж өгсөн. Усны бохирдолоос хамааралтай шүүлтүүр маш хурдан бохирддог 1 сард 1 шүүлтүүр сольдог. Ажиллагаа хэвийн.	Си Ай Ти ХХК
7	Сэлэнгэ НЭ	ЭХО аппарат	Орон нутгийн хөрөнгөөр 3D датчиктай болсон. Хэвийн ажиллагаатай.	Эйч энд эйч ХХК
8	Хөвсгөл НЭ	Хялар тодорхойлогч	Линзийн цуглуулга ирсэн. Градустай линзээ тааруулах нүдний шилний хэмжээтэй рам шаардлагатай	Чоногол трейд ХХК
9	Хөвсгөл НЭ	Гематологийн анализатор	Программын алдаа байнга гарч засварлуулдаг. Суурилуулаад 6 сар болоод эвдэрсэн. Бөглөрөл үүсдэг. Хавтан шатсан. 7,0 сая төг шаардлагатай гэсэн. 3 анализаторын дунд 1 тог баригч тавьсан. Хүчин чадал хангалтгүй.	Сетунари ХХК
10	Хөвсгөл НЭ	Чих сонсгол шалгах автомат аппарат	Тохируулга хийх код нэхдэг.	Чоногол трейд ХХК
11	Хэнтий НЭ	Ходоодны дурангийн иж бүрдэл	Дуранд ус орсон. Баталгаат хугацаандаа үнэ төлбөргүй Япон руу явуулж засуулсан.	Си Ай Ти ХХК

12	Хэнтий НЭ	Бүдүүн гэдэсний дурангийн иж бүрдэл	Дуранд ус орсон. Баталгаат хугацаандаа үнэ төлбөргүй Япон руу явуулж засуулсан.	Си Ай Ти ХХК
13	Хэнтий НЭ	Дижитал ЭХО аппарат	Программ устсан тул дахин суулгасан.	Эйч энд эйч ХХК
14	Хэнтий НЭ	Чихний сонсгол шалгах автомат аппарат	Программын алдаатай тул байнга устгаж суулгаж ажиллуулдаг.	Чоногол трейд ХХК
15	Хэнтий НЭ	Шүдний суурин машины иж бүрдэл /шүдний дэлгэмэл рентген аппараттай/	Наконечник хушуугаа солих түгжээ нь эвдэрсэн. Сэлбэгийг үнэгүй сольсон.	Чоногол трейд ХХК
16	Хэнтий НЭ	Биохимийн анализатор	Бар код таниулахыг зассан, Transmission error алдааг зассан, Кувейт сольсон, Ламп 4 удаа сольсон, Ус цэвэршүүлэгч бодисыг 3 удаа сольсон.	Сетунари ХХК
17	Хэнтий НЭ	Гематологийн анализатор	Wbc буруу High уншиж байсаныг зассан.	Сетунари ХХК
18	Хэнтий НЭ	Коагулаграммийн анализатор	Аппаратын Needle 1 бөглөрсөн шинээр сольсон, PT, APTT, Feb-ын Col control уншуулсан.	Сетунари ХХК
19	Хэнтий НЭ	Шээсний анализатор	Тундас уншигчийн рам гацахыг зассан.	Сетунари ХХК
20	Хэнтий НЭ	Илиза уншигч, уншигч	В С вирусын Col control-г шинээр суулгасан.	Сетунари ХХК
21	Увс НЭ	Ходоодны дуран	Гэмтсэн	Си Ай Ти ХХК

Эдгээрээс харахад Чоногол трейд ХХК-ны нийлүүлсэн чихний сонсгол шалгах аппарат программын гэмтлийн улмаас ажилладаггүй тохиолдол 2-3 аймагт байна. Си Ай Ти ХХК, Сетунари ХХК-уудын хувьд тухайн гэмтэл гарсан тухайд засвар үйлчилгээ хийж, хэвийн ажиллагаанд оруулсан байна.

Монофарм трейд ХХК-ий нийлүүлсэн Компьютер томографийн аппаратын хувьд ашиглалтын хугацаанаас хамаараад зайлшгүй солих шаардлагатай шетка болон рентген хоолой солих санхүүгийн асуудал урган гарч ирч байна.

Хүснэгт 8. Ашиглагдахгүй байгаа тоног төхөөрөмж

№	Аймаг	Тоног төхөөрөмжийн нэр	Ашиглагдахгүй байгаа шалтгаан
1	Баян-Өлгий НЭ	Урологийн дуран	Хүний нөөц бэлтгэгдээгүй
2	Баян-Өлгий НЭ	Тархины доплер	Хүний нөөц бэлтгэгдээгүй
3	Өвөрхангай НЭ Баянхонгор НЭ Сэлэнгэ НЭ Хөвсгөл НЭ Увс НЭ	Шээсний бүрэн автомат анализатор	Урвалж оношлуурын өртөг өндрөөс шалтгаан бүрэн ашиглаагүй
4	Өвөрхангай НЭ Баянхонгор НЭ	Биохимийн бүрэн автомат анализатор	Урвалж оношлуурын өртөг өндрөөс шалтгаан бүрэн ашиглаагүй

5	Увс НЭ	Цус бүлэгнэлтийн анализатор	Урвалж оношлуурын өртөг өндрөөс шалтгаан бүрэн ашиглаагүй
6	Хөвсгөл НЭ	Компьютер томографийн аппарат	Тодосгогчтой зураг авах мэргэжилтэн байхгүй

Хүний нөөцийн бэлтгэгдсэн байдал болон урвалж оношлуурын төсвөөс хамааралтайгаар ашиглагдахгүй байгаа тоног төхөөрөмжүүд мөн оношилгооны төвүүдэд байсаар байна.

Зорилт 7. Гадны хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хүрээнд эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэн болон хийгдэх төсөл хөтөлбөрийн явц, бэлтгэл ажлыг хангуулах/

АХБ-ны ЭМСХХ-V төслийн хүрээнд Цусны салбар банкинд нийлүүлэх цусны тоног төхөөрөмжүүд нийлүүлэгдсэн. Энэхүү төслөөр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжүүд хэвийн ажиллаж байгаа ба Цусны салбар банкны байрны засвар үйлчилгээтэй холбоотой тоног төхөөрөмжүүдийг ашиглахгүй байсан.

Энэхүү төслөөр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжүүд хэвийн ажиллаж байгаа бөгөөд Хагас автомат бүлэгнэлтийн анализатор коагулаграммын аппаратыг хэрхэн ажиллуулах талаар сургалт шаардлагатай байна.

Аймгуудад цусны салбар банкны тоног төхөөрөмжийг байрлуулах засварын ажил цаг хугацааны хувьд оройтож эхэлсэн нь аймгуудын эмчилгээ оношилгоонд зарим нэг талаараа хүндрэл учруулж байна. Жишээ нь: Хөвсгөл аймаг засварын үйл ажиллагаатай холбоотой хүүхдийн тасгийн нүүн байршуулснаар ханиад томуу өвчлөлтийн үед өрөө тасалгааны хүрэлцээ хангагдахгүй байх нөхцөл байдал ажиглагдсан.

Дүгнэлт:

Эрүүл мэндийн сайдын А/143 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг 21 аймгийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төвүүдээр 10 хоног ажиллаа.

Аймгийн ЭМГ, БОЭТ, нэгдсэн эмнэлгийн дарга, удирдлагууд, инженер техникчид, эмч эмнэлгийн мэргэжилтнүүд анх удаа мэргэжлийн баг газар дээр нь ажиллаж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ, шалгалт тохируулга хийж, заавар зөвлөмж өгч ажиллаж байгаад туйлын баяртайгаар энэхүү ажлын хэсгийг талархан хүлээн авч, хамтран ажиллаж тулгамдаж буй асуудал, боломжит засвар үйлчилгээ, эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга хийгдсэн.

Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудаас авсан судалгаа мэдээллээс харахад эмнэлгийн барилга байгууламжийн нөхцөл байдал муудсан, цахилгааны болон сантехникийн засвар үйлчилгээ хийгддэггүй, дээврийн нөхцөл муу ус гоождог, төрөх эмнэлгийн барилгын халаалтын асуудал муу зэрэг асуудлууд байна. Үүнээс гадна эмнэлгийн тусламж үйлчилгээ, түүн дотроо эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах үндсэн техникийн нөхцөл хангалтгүй байна. Ихэнх аймгийн эмнэлгийн барилгад газардуулгын нэгдсэн систем, агааржуулалт, эмнэлгийн хийн систем байхгүй. Зарим аймгууд өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан чухал шаардлагатай мэс засал, сэхээн амьдруулах тасаг, хүүхэд, төрөхийн тасгууддаа хүчилтөрөгчийн шугам татан ашиглаж байна. Ихэвчлэн хуучны барилгууд учраас агааржуулалтын хоолой байгаа боловч ажилладаггүй, чийгтэй, сантехникийн шугамын алдагдлаас бохирын үнэртсэн, мөн усны чанарын асуудлаас хамаарах усны

шүүлтүүрийн бохирдолоос хамаарч тоног төхөөрөмжийн ажиллагаанд нөлөөлөх асуудлууд үүсдэг байна.

Мөн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангамжийн асуудал стандарт шаардлагад хүрдэггүй, дутагдалтай байдаг бөгөөд цаашид **26.0 тэрбум** төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай гэсэн тоон судалгаа гарлаа.

Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад эмнэлгийн тоног төхөөрөмжийг стандарт хангасан хангамжид шаардлагатай хөрөнгө оруулалтаас хэрэгтэйгээс гадна тухайн тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа, ашиглалт аюулгүй байдлыг ханган ажиллах, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, засвар үйлчилгээг бүрэн хариуцах эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерийн баг хангалтгүй байна. Сэлэнгэ аймагт инженер байхгүй, 1 техникчтэй ажиллаж байна. Орон тоо дутуу ажилласанаар тухайн инженер, техникчдын ажлын ачаалал нэмэгдэж, засвар үйлчилгээний ачаалалаас хамаарч бусад үйл ажиллагаа хөрөнгө оруулалтын төлөвлөлт, эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагаа болон эмч эмнэлгийн мэргэжилтний ажлын байрны сургалт хангалтгүй байх нөхцөл байдлыг бүрдүүлж байна.

Эрүүл мэндийн сайдын 2006 оны 439 дугаар тушаалын хэрэгжилт хангалтгүй, тушаалын дагуу бүрэн орон тоогоор ажиллаж байгаа аймаг байхгүй, аймгийн эрүүл мэндийн газарт тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн нь эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэргэжлийн бус эмзүйч, санхүүгийн болон мэдээллийн технологийн мэргэжилтэн ажиллаж байгаа нь тухайн аймгийн сум, сум дундын эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвд ашиглагдаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн төлөвлөлт, хуваарилалт, засвар үйлчилгээ, сургалтын асуудал орхигдож байна. Ганцхан Өвөрхангай аймгийн эрүүл мэндийн газар нь эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер мэргэжилтэй хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн ажиллаж байгаа бөгөөд ийм хүн ажилласнаар аймгийн сумдуудад ашиглагдахгүй байсан илүүдэлтэй тоног төхөөрөмжийн судалгаа гаргаж, зохих засвар үйлчилгээг хийж, шаардлагатай газар нь хуваарилж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг болсон байна.

Аймгийн эрүүл мэндийн байгууллагууд илүүдэлтэй болон ашиглагдахгүй тоног төхөөрөмжийн судалгаа ирүүлэхдээ цаашид ашиглах боломжгүй, актлагдах тоног төхөөрөмжийг оруулан ирүүлсэн нь илүүдэлтэй тоног төхөөрөмж их байгаа мэт харагдаж байгаа боловч, газар дээр нь тухайн судалгаанд ирүүлсэн тоног төхөөрөмжөөс цаашид ашиглагдах боломжтой нийт 5 нэр төрлийн тоног төхөөрөмж байгаа бөгөөд цаашид хэрэгцээтэй газар нь шилжүүлэн ашиглах боломжтой байна.

Эрүүл мэндийн харьяа төв эмнэлгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн 5 инженер 21 аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгооны эмчилгээний төвийн гэмтэлтэй байсан **180** тоног төхөөрөмжийг газар дээр нь завсарлан хэвийн үйл ажиллагаанд оруулж, **52** тоног төхөөрөмжийн гэмтлийг оношилсон байна.

Тухайн газар дээр нь засварлах боломжгүй тоног төхөөрөмжийн гэмтлийг оношилж, тэдгээрт шаардлагатай сэлбэг хэрэгслийн тооцоог гаргасан бөгөөд 21 аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний сэлбэг хэрэгсэлд **434,6 сая** төгрөг шаардлагатай байна.

Эрүүл мэндийн хөгжлийн Мэдээллийн технологи, эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны мэргэжилтнүүд нийт 8 төрлийн тоног төхөөрөмжийн 224 ширхэг тоног төхөөрөмжид **12,1сая** төгрөгийн өртөгтэй шалгалт тохируулгын ажил хийж гүйцэтгэсэн ба үүнээс шаардлагад нийцсэн 122 тоног төхөөрөмж, нийцээгүй тоног төхөөрөмж 102 байгаа бөгөөд шаардлага хангасан тоног төхөөрөмж 45,5%-тай байгаа нь шалгалт

тохируулгын дараах засвар тохируулгын асуудал зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.

Ерөнхий сайдын хөрөнгө оруулалтаар 11 аймгийн оношилгооны нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн ашиглалтын нөхцөл байдалтай танилцаж, 2014-2016 онд тухайн тоног төхөөрөмжөөр оношилгоо, шинжилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоог гаргаж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг тодорхойлсон. Мөн үүнээс гадна тухайн багцад нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэлтэй тоног төхөөрөмжийн судалгаа гарган авсан ба ханган нийлүүлэх байгууллагад хандах, мөн эдгээр тоног төхөөрөмжийн баталгааны хугацаа дуусаж байгаатай холбогдуулан цаашдын засвар үйлчилгээний байдал, хугацаат сэлбэг хэрэгслийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх шаардлага тулгарч байна. Мөн хүний нөөц, мэргэжилтэнгүйн улмаас ашиглагдахгүй байгаа тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулах шаардлагатай байна.

АХБ-ны ЭМСХХ-V төслийн хүрээнд Цусны салбар банкинд нийлүүлэх цусны тоног төхөөрөмжүүд нийлүүлэгдсэн. Энэхүү төслөөр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжүүд хэвийн ажиллаж байгаа ба Цусны салбар банкны байрны засвар үйлчилгээтэй холбоотой тоног төхөөрөмжүүдийг ашиглахгүй байсан. Аймгуудад цусны салбар банкны тоног төхөөрөмжийг байрлуулах засварын ажил цаг хугацааны хувьд оройтож эхэлсэн нь аймгуудын эмчилгээ оношилгоонд зарим нэг талаараа хүндрэл учруулж байна.

Санал:

1. Аймгийн эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг (газардуулгын систем, агааржуулалт, эмнэлгийн хийн систем, цахилгааны нөөц үүсгэвэр) сайжруулах
2. Аймгуудын бүсчилсэн хувааж, эмнэлгийн зориулалтын хүчилтөрөгчийн үйлдвэр байгуулах
3. Аймгийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төвийн инженер техникчдын бүтэц орон тоог шинэчлэгдэн боловсруулагдах эрүүл мэндийн байгууллагын бүтэц үйл ажиллагааны стандартад нарийвчлан оруулах
4. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн байгууллагын бүтэц үйл ажиллагааны стандартын В хавсралтаар заагдсан Эмнэлгийн тоног төхөөрөмжийн жагсаалтыг шинэчлэн боловсруулах
5. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалтыг оновчтой болгох, засвар үйлчилгээний нэгдсэн зохицуулалт, засвар үйлчилгээнд шаардлагатай сэлбэг, хугацаат сэлбэг хэрэгслийн төсвийн зардлын тусдаа зүйл анги болгон төсөвт суулгах,
6. Урвалж оношлуурын төсвийн зардлын эм, эмнэлгийн хэрэгслийн зардлаас тусдаа анги болгон төсөвт суулгах
7. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын дараах засвар тохируулгын үйл ажиллагааг яаралтай эхлүүлэх, явуулын засвар үйлчилгээний автомашинтай болж, засвар үйлчилгээний баг бэлтгэх